



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/12

Шивээговь сум

Төсөл, арга хэмжээг төлөвлөхөд арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөхөд арга зүйн зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Засаг даргын Тамгын газрын дарга 1 дүгээр багийн Засаг дарга 2 дугаар багийн Засаг дарга Санхүүгийн албаны дарга Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч Хөдөө аж ахуйн тасгийн дарга Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн Нийгмийн бодлогын мэргэжилтэн Байгаль орчны асуудал хариуцсан

4212 0017

мэргэжилтэн


Газрын даамал

Ж.Баярцэцэг

(1 дүгээр багийн иргэн)

2. “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд иргэдээс гарсан саналыг багцлах, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах, дүн шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлэн багийн Иргэдийн нийтийн хурлаас ирүүлсэн саналыг нэгтгэж, санал нэг бүрийг хэлэлцэн дүгнэлт гаргаж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг бэлтгэн Засаг даргын зөвлөлд 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга /Засаг даргын орлогч/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ